



IAF Mandatory Document

ОУИФ Заавал мөрдөх баримт бичиг

**ИТГЭМЖЛЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН  
ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН  
БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ӨМНӨӨС ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН  
НЭГЖИД ХЯНАЛТ ТАВИХ НЬ**

**CONTROL OF ENTITIES OPERATING ON  
BEHALF OF ACCREDITED  
MANAGEMENT SYSTEMS  
CERTIFICATION BODIES**

**Хэвлэл 2**

**(IAF MD 23:2023)**

Хэвлэсэн огноо: 20.12.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 20.12.2023

Олон Улсын Итгэмжлэлийн Форум (ОУИФ) нь ОУИФ-ын гишүүнээр итгэмжлэгдсэн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын гаргасан үр дүнг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, Итгэмжлэлийн байгууллага (ИБ)-уудын дунд дэлхий хэмжээний харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэгч болон зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн худалдааг хөнгөвчилдөг.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд итгэмжлэлийн хамрах хүрээнд багтсан ажлаа гүйцэтгэх чадамжтайг батлах замаар бизнес болон тэдгээрийн хэрэглэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг. ОУИФ-ын гишүүн ИБ болон тэдгээрийн итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь олон улсын стандарт, тэдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулсан ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг мөрдөх шаардлагатай.

ОУИФ-ын Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн ИБ-уудын итгэмжлэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд итгэлийг бий болгохын тулд ижил түвшний багаас бүрдсэн үнэлгээг тогтмол явуулдаг. ОУИФ-ын ХХЗХ-ийн бүтцийн талаар ОУИФ-ын бодлогын баримт бичиг 3 (IAF PL 3) “ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний бүтэц ба ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний өргөтгөлийн бодлого, журам”-д дэлгэрэнгүй тусгасан. Мөн ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний талаар ОУИФ-ын ХХЗХ-ийн статус баримт бичигт тусгасан.

ОУИФ-ын ХХЗХ-ийн нь дараах таван түвшний бүтэцтэй. Үүнд:  
1-р түвшин нь ISO/IEC 17011 стандартыг хэрэгжүүлэгч бүх ИБ-уудад хамаарах заавал мөрдөх шалгуурыг тодорхойлно. 2-р түвшний үйл ажиллагаа болон холбогдох 3-р түвшний норматив баримт бичиг(үүд)-ийн нэгдлийг ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээ

The International Accreditation Forum, Inc. (IAF) facilitates trade and supports industry and regulators by operating a worldwide mutual recognition arrangement among Accreditation Bodies (ABs) in order that the results issued by Conformity Assessment Bodies (CABs) accredited by IAF members can be accepted globally.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited CABs are competent to carry out the work they undertake within their scope of accreditation. ABs that are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

ABs that are signatories to the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) are evaluated regularly by an appointed team of peers to provide confidence in the operation of their accreditation programs. The structure of the IAF MLA is detailed in IAF PL 3 - Policies and Procedures on the IAF MLA Structure and for Expansion of the Scope of the IAF MLA. The scope of the IAF MLA is detailed in the IAF MLA Status document.

The IAF MLA is structured in five levels: Level 1 specifies mandatory criteria that apply to all ABs, ISO/IEC 17011. The combination of a Level 2 activity(ies) and the corresponding Level 3 normative document(s) is called the main scope of the MLA, and the combination of Level 4 (if applicable) and Level 5 relevant normative documents is called a sub-scope of the MLA.

гэж нэрлэдэг. 4-р түвшин (хэрэв байгаа бол) болон 5-р түвшний холбогдох норматив баримт бичгийн нэгдлийг ХХЗХ-ийн дэд хамрах хүрээ гэж нэрлэдэг.

- ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалт гэх мэт үйл ажиллагаа болон ISO/IEC 17065 зэрэг холбогдох заавал мөрдөх стандарт багтана. Үндсэн хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил найдвартай гэж үзнэ.
- ХХЗХ-ийн дэд хүрээнд тохирлын үнэлгээний шаардлагууд буюу ISO 9001 болон схемийн тусгай шаардлага, тухайлбал ISO 22003-1 стандартууд багтана. Дэд хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил тэнцүү гэж үзнэ.

ОУИФ-ын ХХЗХ нь тохирлын үнэлгээний үр дүнг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг төрүүлдэг. ОУИФ-ын ХХЗХ-т гарын үсэг зурсан ИБ-аар итгэмжлэгдсэн байгууллагын ОУИФ-ын ХХЗХ-ийн хүрээнд гаргасан баталгааг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, улмаар олон улсын худалдааг хөнгөвчилнө.

## Хэвлэл 2

Боловсруулсан: ОУИФ-ын Техникийн хороо  
Баталсан: ОУИФ-ын гишүүд  
Огноо: 03.12.2023  
Хэвлэсэн огноо: 20.12.2023  
Хэрэгжиж эхлэх огноо: 20.12.2023  
Холбоо барих: Элва Нилсен  
ОУИФ Нарийн бичгийн дарга  
Утас: +1 613 454-8159  
И-мейл: secretary@iaf.nu

- The main scope of the MLA includes activities e.g. product certification and associated mandated standards e.g. ISO/IEC 17065. The attestations made by CABs at the main scope level are considered to be equally reliable.
- The sub scope of the MLA includes conformity assessment requirements e.g. ISO 9001 and scheme specific requirements, where applicable, e.g. ISO 22003-1. The attestations made by CABs at the sub scope level are considered to be equivalent.

The IAF MLA delivers the confidence needed for market acceptance of conformity assessment outcomes. An attestation issued, within the scope of the IAF MLA, by a body that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide, thereby facilitating international trade.

## Issue 2

Prepared by: IAF Technical Committee  
Approved by: IAF Members  
Date: 03 December 2023  
Issue Date: 20 December 2023  
Application Date: 20 December 2023  
Name for Enquiries: Elva Nilsen  
IAF Corporate Secretary  
Contact Phone: +1 (613) 454 8159  
Email: secretary@iaf.nu

## АГУУЛГА

0. ХАМРАХ ХҮРЭЭ
1. Баталгаажуулалтын байгууллагын үүрэг
  - 1.1 Боломжит буюу нэр дэвшиж буй аж ахуйн нэгжийн эрсдэлийн үнэлгээ
  - 1.2 Хуулийн хүчин төгөлдөр гэрээ байгуулах нь
  - 1.3 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь холбогдох шаардлага, ББ-ын менежментийн тогтолцоо, засаглалын баримт бичигт нийцэж буй байдал
2. Итгэмжлэлийн байгууллагын үүрэг
  - 2.1 ИБ-ын аж ахуйн нэгжийн мониторинг
  - 2.2 ИБ-ын аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үнэлгээ

Хавсралт 1: Эрсдэлийн үнэлгээний үеэр шалгаж болох элементүүд (мэдээллийн)

Хавсралт 2: Хуулийн этгээдийн үйл ажиллагааны тусгай хянан шалгалтын үнэлгээний аргууд (мэдээллийн)

## TABLE OF CONTENTS

0. SCOPE
1. Obligations of Certification Bodies
  - 1.1 Risk Assessment of Candidate Entities
  - 1.2 Establishment of the Legally Enforceable Agreement
  - 1.3 Compliance of Entities' Operations with the Applicable Requirements and the CB Management System and Governance Documents
2. Obligations of Accreditation Bodies
  - 2.1 AB Monitoring of Entities
  - 2.2 AB Assessment of Entities' Operations

Annex 1: Elements That Can Be Checked During the Risk Assessment (Informative)

Annex 2: Toolset for Special Investigative Assessment of Entities' Operations (Informative)

## **ОУИФ-ЫН ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА**

Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байвал зохино” нэр томъёо нь шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллагад (ИБ) нотлон харуулсан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байх ёстой” нэр томъёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

## **INTRODUCTION TO IAF MANDATORY DOCUMENTS**

The term “should” is used in this document to indicate recognised means of meeting the requirements of the standard. A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term “shall” is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

**ИТГЭМЖЛЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН  
ТОГТОЛЦООНЫ  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН  
БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ӨМНӨӨС  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ  
АХУЙН НЭГЖИД ХЯНАЛТ ТАВИХ НЬ**

**0. ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү баримт бичиг нь итгэмжлэлтэй баталгаажуулалтын байгууллага (ББ)-уудын нэрийн өмнөөс менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа болон/эсвэл удирдаж буй аж ахуйн нэгжүүдэд хамаарах бөгөөд эдгээр нь ББ-ын бүрэн буюу хэсэгчлэн эзэмшдэггүй эсхүл ажилладаггүй байгууллагуудыг хамарна. Аж ахуйн нэгжүүд нь ББ-ын төв оффистой нэг улсад байрладаг эсхүл байрладаггүй байж болох ба ББ-ын төлөөлөгч, агентлаг, франчайз эзэмшигч, борлуулалтын алба эсвэл ББ-тай баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах гэрээний харилцаатай аливаа байгууллага байж болно.

Норматив эш таталт:

ISO/IEC 17011 - Тохирлын үнэлгээ. Тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх итгэмжлэлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага

ISO/IEC 17021-1 - Тохирлын үнэлгээ - Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага - 1-р хэсэг: Шаардлага

**1. БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ**

**1.1 Боломжит буюу нэр дэвшиж буй аж ахуйн нэгжийн эрсдэлийн үнэлгээ**

ББ нь аливаа гэрээ хэлэлцээр байгуулахын өмнө өөрийн оршин суугаа улс болон ББ-ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах улс орнуудад нэр дэвшиж буй аж ахуйн нэгжид эрсдэлийн иж

**CONTROL OF ENTITIES OPERATING  
ON BEHALF OF ACCREDITED  
MANAGEMENT SYSTEMS  
CERTIFICATION BODIES**

**0. SCOPE**

This document relates to entities, performing and/or managing management system certification activities, on behalf of certification bodies (CBs) holding accreditation, which are not wholly or partly owned or employed by the CB. The entities may or may not be located in the same country as the CB head office and may be a representative, agency, franchisee or sales office of the CB or any entity which has a contractual relationship with the CB for performing certification activities.

Normative references:

ISO/IEC 17011:2017 – Requirements for accreditation bodies accrediting conformity assessment bodies

ISO/IEC 17021-1:2015 – Requirements for bodies providing audit and certification of management systems -- Part 1: Requirements

**1. OBLIGATIONS OF CERTIFICATION BODIES**

**1.1 Risk Assessment of Candidate Entities**

Prior to entering any agreement, the CB shall perform a comprehensive risk assessment on the candidate entity in the country in which it is located and in the countries in which it will be

бүрэн үнэлгээ хийнэ. Хэрэв удирдах боломжгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй эрсдэлийг тодорхойлсон бол ББ гэрээг үргэлжлүүлэхгүй. ББ-аас тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй улс орны баталгаажуулалтын бизнесийн шударга байдал, чадамж, тууштай байдал, бие даасан байдал, орон нутгийн эрсдэлийн түвшинг харгалзан эрсдэлийг авч үзнэ. (Хавсралт 1-ийг үзнэ үү.) Мөн аж ахуйн нэгжийн одоо байгаа итгэмжлэлийг харгалзан үзэж болно.

## **1.2 Хуулийн хүчин төгөлдөр гэрээ байгуулах нь**

ББ нь нэр дэвшиж буй аж ахуйн нэгжтэй дараах зүйлсийн дагуу (үүгээр хязгаарлагдахгүй) хуулийн дагуу хүчин төгөлдөр гэрээ байгуулна, Үүнд:

- i) Нэр дэвшигч аж ахуйн нэгж нь эрх зүйн байдал, шударга байдал, чадамжийн шаардлага, үйл явцын шаардлага, ББ-ын менежментийн тогтолцоо зэрэг холбогдох шаардлагад нийцсэн байх бөгөөд энэ нь нэр дэвшигч баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэхэд оролцоно.
  - Нэр дэвшигч аж ахуйн нэгж нь ББ-ын менежментийн тогтолцоо болон/эсвэл өөрийн итгэмжлэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
  - Шаардлагатай тохиолдолд эрсдэлийн үнэлгээнд үндэслэн нэмэлт хяналтыг тодорхойлж хэрэгжүүлнэ.
- ii) Байгууллага нь ББ-аас байнгын аудитад хамрагдана. Аудит нь ББ-ын нэрийн өмнөөс тухайн байгууллагын гүйцэтгэсэн бүх үйл ажиллагааг хамруулна. Аудитын давтамж, аргачлал нь эрсдэлийн үнэлгээ болон өмнөх аудитын үр дүнгээс хамаарна.
- iii) IAF MD 15: Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хангах зорилгоор мэдээлэл цуглуулах тухай ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг багтаасан гүйцэтгэлийн үндсэн

operating on behalf of the CB. If it identifies an unacceptable risk that is not manageable, the CB shall not proceed with the agreement.

The risks shall be considered with regard to impartiality, competence, consistency, independence, and levels of local risk to certification business in the country where the CB is planning for the entity to operate. (See Annex 1.) Existing accreditation of the entity can be taken into account.

## **1.2 Establishment of the Legally Enforceable Agreement**

The CB shall establish a legally enforceable agreement with the candidate entity to include but not be limited to:

- i) That the candidate entity shall conform to the applicable requirements including legal status, impartiality, competence requirements, process requirements and with the CB's management system, to the extent that the candidate entity is involved in the delivery of certification services.
  - The candidate entity shall operate within the CB's management system and/or under its own accreditation.
  - As needed, based on the risk assessment, additional controls shall be defined and implemented.
- ii) The entity is subject to audit by the CB on an ongoing basis. The audits shall include all activities performed by the entity on behalf of the CB. The audit frequency and methodology shall depend on the risk assessment and the results of previous audits.
- iii) Mandatory annual reporting on key performance indicators (KPIs), including those specified in IAF MD 15: IAF Mandatory Document for the Collection of Data to Provide Indicators of Management System Certification Bodies' Performance.

шалгуур үзүүлэлтүүдийн (KPI) жилийн тайлан.

- iv) Шаардлагатай гэж үзвэл ББ-ын итгэмжлэлийн байгууллага (ИБ)-аас хяналт, мониторинг хийх боломж олгох.
- v) Аж ахуйн нэгжээс өгөх үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл.
- vi) Тал бүрийн хариуцлага, эрх мэдэл, үүрэг.
- vii) Нөөцөөр хангах, сургах, тасралтгүй мэргэжил дээшлүүлэх.
- viii) Оюуны өмч ба хамгаалалт.
- ix) Аж ахуйн нэгж нь ББ-ын нэрийн өмнөөс гүйцэтгэж буй аливаа үйл ажиллагааг аутсорсинг хийхээс өмнө ББ-ын зөвшөөрлийг авна.

ББ-ууд нь бүх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн талаар ИБ-д тайлагнана.

Гэрээ нь цуцлагдсан тохиолдолд ББ нь тухайн цуцлах болсон үндэслэлээ ИБ-д мэдэгдэнэ.

### **1.3 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь холбогдох шаардлага, ББ-ын менежментийн тогтолцоо, засаглалын баримт бичигт нийцэж буй байдал**

Холбогдох итгэмжлэлийн шаардлагуудыг дагаж мөрдөх шаардлага нь ББ-ын нэрийн өмнөөс үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой аж ахуйн нэгжид хамаарна.

ББ нь аж ахуйн нэгжийн байнгын гүйцэтгэл, түүний дотор дотоод аудит, (газар дээр, зайнаас эсвэл хосолсон аргуудыг багтаасан гэрчлэх аудитыг оролцуулан) ББ-ын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн холбогдох шаардлага, ББ-ын засаглалын баримт бичиг, ББ-ын нэрийн өмнөөс гүйцэтгэсэн үйл ажиллагаатай холбоотой холбогдох бусад баримт бичигт хяналт тавина.

## **2. ИТГЭМЖЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ**

- iv) Provision of access to control and monitoring by the CB's Accreditation Body (AB) as deemed necessary.
- v) Details of the activities to be provided by the entity.
- vi) Responsibilities, authority and liability of each party.
- vii) Provision of resources, training, continuous professional development.
- viii) Intellectual property and protection.
- ix) Before outsourcing any activities it performs on behalf of the CB, the entity shall obtain the agreement of the CB.

CBs shall report to their ABs all established entities' operations and the markets in which they operate.

In cases of termination of the agreement, the CB shall inform its AB with the reasons of termination.

### **1.3 Compliance of Entities' Operations with the Applicable Requirements and the CB Management System and Governance Documents**

The requirement to conform to the applicable accreditation requirements is extended to the entity, in relation to the services it performs on behalf of the CB.

CBs shall monitor the ongoing performance of the entity, including internal audits, (including witnessing audits that may include on-site, remote or a combination of methods) of the entities to the relevant accreditation requirements of the CB's management system, the CB's Governance Documents and other applicable documents in relation to the activities performed on behalf of the CB.

## **2. OBLIGATIONS OF ACCREDITATION BODIES**

## **2.1 ИБ-ын аж ахуйн нэгжийн мониторинг**

Ийм аж ахуйн нэгжийг ББ-д ашиглахыг ИБ-д мэдэгдэх үед ИБ нь энэ мэдээллийг (ISO/IEC 17011-ийн 7.8.1-д заасан) орон нутгийн ИБ(ууд)-тай хуваалцах бөгөөд ISO/IEC 17011 станлартын 8-р зүйлийн дагуу шаардлагыг харгалзан тэдний саналыг авч болно.

Орон нутгийн ИБ-ууд анхааралдаа авахдаа дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй гадаадын ИБ-аар итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүдийг тодорхойлж, энэ мэдээллийг гадаадын ИБ-д мэдээлнэ.

ББ-ын ИБ нь ISO/IEC 17011, IAF MD 12: Олон оронд үйл ажиллагаа явуулж буй тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн үнэлгээ болон холбогдох бусад баримт бичгийн шаардлагын дагуу өөрийн байгууллагуудын үнэлгээний хөтөлбөрийг шийдвэрлэж, шаардлагатай бол орон нутгийн ИБ-д мэдэгдэнэ.

ББ-ын ИБ нь залилан мэхэлсэн, ёс зүйгүй үйлдэл гаргасан тохиолдолд ББ болон аж ахуйн нэгжийн хооронд байгуулсан гэрээг цуцалсан тохиолдолд орон нутгийн ИБ-д мэдэгдэнэ.

## **2.2 ИБ-ын аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үнэлгээ**

ИБ-ууд нь ISO/IEC 17011 стандартын шаардлага болон IAF-ийн холбогдох баримт бичигт үндэслэн итгэмжлэлийн мөчлөг дэх ББ болон түүний аж ахуйн нэгж бүрийн үнэлгээний давтамжийг тодорхойлно.

ББ-ын ИБ нь сөрөг хандлагаас үүдсэн тодорхой нөхцөл байдлыг судлахын тулд аж ахуйн нэгжүүдийн үнэлгээг эхлүүлж болно (үүнд аж ахуйн нэгжүүд болон ББ-аас тодорхойлох шаардлагатай шалгуур үзүүлэлтүүд болон ИБ-д тогтмол мэдээлдэг) эсвэл зах зээлийн санал хүсэлт, тухайлбал:

## **2.1 AB Monitoring of Entities**

When an AB is notified that such an entity is to be used by a CB, the AB shall share this information (clause 7.8.1 of ISO/IEC 17011) with local AB(s) and may seek their inputs taking into account the requirements of clause 8 of ISO/IEC 17011.

Local ABs shall identify, when it comes to their attention, entities, accredited by foreign ABs, operating in the local market and communicate this information to the foreign AB.

The CB's AB shall decide on an assessment program of its entities in accordance with the requirements of ISO/IEC 17011, IAF MD 12: Accreditation Assessment of Conformity Assessment Bodies with Activities in Multiple Countries and other applicable documents and shall inform the local AB if applicable.

The CB's AB shall inform the local AB of cases of termination of the agreement between the CB and the entity for fraudulent or unethical behavior.

## **2.2 AB Assessment of Entities' Operations**

ABs shall determine the frequency of assessment for each CB and its entities in an accreditation cycle based on the requirements of ISO/IEC 17011 and the applicable IAF documents.

The CB's AB may initiate assessments of entities to investigate specific situations triggered by adverse trends (including the indicators that are required to be identified by the entities and the CB and reported on a regular basis to the AB) or market feedback, such as:

- ББ-аас олгосон гэрчилгээний тоо гэнэт өөрчлөгдсөн.
- Аж ахуйн нэгж нь аудит хийж байгаа бол, жишээ нь баталгаажуулалтын мөчлөгийн туршид, урт хугацааны туршид үл тохирлын зөрчил цөөн буюу огт гаргадаггүй.
- Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын найдвартай байдалд эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал.
- Аж ахуйн нэгжийн баталгаажуулалтын үйл явцын үр дүнтэй байдлын талаар санаа зовниж буйг харуулсан гэрчилгээжсэн байгууллагын үйлчлүүлэгчид болон бусад сонирхогч талуудаас ирсэн гомдол.
- Сөрөг сурталчилгаа: тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас тодорхой бүтээгдэхүүн, байгууллага, аж ахуйн нэгжийн талаар техникийн тодорхой чиглэлтэй холбоотой асуудал; нийгмийн сүлжээний сайтуудаар дамжуулан тодорхойлсон асуудлууд; магадлан итгэмжлэгдсэн баталгаажуулалтын гүйцэтгэлтэй холбоотой төрийн бус байгууллагуудын тодорхой сөрөг санал хүсэлт.
- Зохицуулагчдын хөндлөнгийн оролцоо, эсвэл зохицуулагчийн сөрөг санал.
- Өмнө нь нэг үйлчлүүлэгч, ялангуяа нэг аудитор/багийн хийсэн аудитын явцад ийм дүгнэлт гараагүй байхад ИБ-аас үйлчлүүлэгчийн гэрчлэгдсэн үнэлгээний явцад байгууллагын системтэй холбоотой асуудал болон санаа зовоосон асуудлуудыг дэвшүүлсэн.
- Зохицуулалтын шаардлага, ялангуяа ХАБМТ, БОМТ эсвэл ХАБЭАМТ зэрэг зохицуулалтад мэдрэмтгий менежментийн тогтолцоонд, ялангуяа хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд нөлөөлж байгаа тохиолдолд хангалттай аудит хийгээгүйг нотлох баримт.

Тайлбар: Хавсралт 2-ыг ийм нөхцөл байдлыг судлахад ашиглаж болно.

Байгууллагын гүйцэтгэл муу байгаа тохиолдолд (орон нутгийн ИБ, зохицуулах байгууллага эсвэл бусад сонирхогч талуудын

- A sudden change in the number of certificates issued by the CB.
- The entity raises few or no nonconformities during a long period of time, for example over a certification cycle, if the entity is performing audits.
- Situations that call into question the credibility of accredited certification.
- Complaints from customers of certified organizations or other interested parties indicating concerns about the effectiveness of an entity's certification process.
- Negative publicity: i.e. issues raised by media organizations regarding a particular product, organization or entity, with relation to specific technical areas; problems identified through social networking sites; specific negative feedback from NGOs regarding the performance of accredited certification.
- Intervention from regulators, or negative feedback from regulators.
- The raising of systemic issues and concerns by the entity during witnessed assessment by the AB for a client when no such findings were recorded in earlier audits of the same client, especially by the same auditor/team.
- Evidence that regulatory requirements, especially in regulation-sensitive management systems such as FSMS, EMS or OHSMS, are not adequately audited, particularly if there is a direct impact on people's health or safety.

Note: Annex 2 can be used to assist the investigation of such situations.

In the event of poor performance by the entity (which can be triggered by complaints from local ABs, regulatory bodies or other

гомдол, бүртгэл муутай, орон нутгийн ажилтнуудын сургалт, үнэлгээ үр дүн муутай гэх мэт) газар дээр нь, алсын зайнаас эсвэл хосолсон аргуудыг багтаасан нэмэлт тусгай үнэлгээ зэргийг програмчлах замаар ББ-ын үнэлгээний хөтөлбөрийг ИБ өөрчлөх шаардлагатай.

Муу үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжтэй холбоотой мэдээллийг орон нутгийн ИБ-тай хуваалцаж, цаашид авах арга хэмжээний талаар ББ-тай тохиролцсоны дагуу хамтран ажиллана.

stakeholders, poorly maintained records, non-effective training and evaluation of local staff, etc.), an AB may need to change the assessment program of the CB, e.g., by programming additional special assessments that may include on-site, remote or a combination of methods.

Information related to poorly performing entities shall be shared with the local AB, and its cooperation requested for any subsequent action, with the agreement of the CB.

## **Хавсралт 1: Эрсдэлийн үнэлгээний үеэр шалгаж болох элементүүд (мэдээллийн)**

Эрсдэлийн үнэлгээний явцад шалгаж болох элементүүд нь үүгээр хязгаарлагдахгүй:

- Өмчлөгч ба өмчлөгчид, тэдгээрийн харилцаа (бизнес болон бусад).
- Холбоотой бизнес, түүний дотор зөвлөх компаниудтай харилцах харилцаа.
- Эзэмшигч болон аж ахуйн нэгжийн эрүүгийн бүртгэл - цэвэр бүртгэл.
- Эрх бүхий албан тушаалтнууд, зөрчил, акт, хориг, татварын бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэлтэй холбоотой байж болзошгүй асуудал.
- Бусад ТБ-тай урьд нь харилцаа тогтоосон, хэрэв байгаа бол одоогийн байдал, харилцаагаа таслах шалтгаан.
- Бүртгэлд байгаа ажилчдын тоо, түүний дотор гадаад нөөц.
- Аудиторын чадамжийн хүрээ, аудиторын файлууд, одоогийн гэрээ.
- Санхүүгийн тогтвортой байдал.

*Тайлбар: Орон нутгийн ИБ нь мэдээллийн эх сурвалж байж болно.*

## **Хавсралт 2: Хуулийн этгээдийн үйл ажиллагааны тусгай хянан шалгалтын үнэлгээний аргууд (мэдээллийн)**

Тусгай хянан шалгалтын үнэлгээ шаардлагатай бол байгууллагуудын үйл ажиллагааны тохирлын нотолгоог үнэлэхийн тулд шалгаж болох сэдвүүдийн жагсаалтыг доор харуулав. Үүнд:

- Компани болон өмчлөгч/менежерүүдийн хууль эрх зүйн мэдээлэл, бүртгэл, өмчлөх эрх, хууль ёсны бүртгэл.
- Аж ахуйн нэгжийн гүйцэтгэх бусад төрлийн үйл ажиллагаа.
- Нийтлэг өмчлөл болон өмчлөгчдийн хоорондын холбоосоор дамжуулан холбогдох байгууллагууд.
- Удирдлагын бүтэц, ашиг сонирхлын зөрчлийн менежмент.
- Татвар, нийгмийн даатгалын мэдээлэл, ажлын хэмжээ, захидал харилцаа.
- Аудиторын нөөц - тэдгээрийн оршин тогтнох болон харуулсан ур чадварын нотолгоо.
- Санхүүгийн тал.
- Аудитын огноог хооронд нь нягтлан шалгах, аудитууд байгаа эсэхийг нотлох баримт (жишээ нь аялалын баримт, зочид буудлын нэхэмжлэх, төлбөрийн мэдээлэл бусад аудиттай давхцахгүй байх).
- Үйлчлүүлэгчидтэй аудитын баг байгаа эсэх, аудитын өдрүүд, аудитын үргэлжлэх хугацаа гэх мэтийг баталгаажуулах.
- Компанийн бодит байдал.
- Шууд зардалтай харьцуулах хувь хэмжээг шалгах.
- Томоохон зөвлөх туслан гүйцэтгэгчдийг шалгах - туслан гүйцэтгэгчид их хэмжээний төлбөр төлөх;
- Аудиторуудад төлөх төлбөр, аудиторуудтай хийсэн гэрээ, аудит хийх компаниудын төлбөр.

Шаардлагатай бол шалгах бусад агуулгуудыг нэмж болно.

## **Annex 1: Elements That Can Be Checked During the Risk Assessment (Informative)**

Elements that can be checked during the risk assessment include but are not limited to:

- Ownership and owners and their relationships (business and other).
- Related businesses, including relationships with consulting companies.
- Criminal records of owners and entity - clean records.
- Potential issues with authorities, violations, acts, bans, tax records, social security records.
- Former relations with other CBs, if any, current status, reasons for termination of relationships.
- Number of employees on record, including external resources.
- Scopes of competence of auditors, auditor files, current contracts.
- Financial stability.

*Note: The Local AB may be a source of information.*

## **Annex 2: Toolset for Special Investigative Assessment of Entities' Operations (Informative)**

If a special investigative assessment is necessary, below is a recommended list of topics that can be checked to assess the evidence for conformity of entities' operations:

- Legal information, registration, ownership, legal records of company and owners/managers.
- Other types of activity performed by the entity.
- Related entities through common ownership and links between owners.
- Management structure and management of conflict of interest.
- Tax and social security information and correspondence with volume of work.
- Auditor resources - evidence of their existence and their demonstrated competence.
- Financial aspects.
- Cross-check of dates of audits and hard evidence for the presence of the auditors (for example that travel receipts, hotel invoices, payment details do not overlap with other audits).
- To confirm with clients the presence of audit teams, audit days, length of audits, etc.
- Actual state of the company.
- Check rates against direct costs.
- Check for large consulting subcontractors - large amounts paid to subcontractors; payments to auditors, contracts with auditors, payments to companies to do audits.

Other topics for checking may be added, as required.

*Итгэмжлэгдсэн менежментийн  
тогтолцооны баталгаажуулалтын  
байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа  
явуулж буй аж ахуйн нэгжид хяналт тавих  
ОУИФ-ын заавал мөрдөх баримтч бичгийн  
төгсгөл*

*End of IAF Mandatory Document Control of  
Entities Operating on Behalf of Accredited  
Management Systems Certification Bodies*

**Нэмэлт мэдээлэл:**

Тус баримт бичиг болон ОУИФ-ын бусад баримт бичгийн талаарх нэмэлт мэдээллийг ОУИФ-ын гишүүн, нарийн бичгийн дарга нарын газартай холбогдоно уу.

ОУИФ-ын гишүүдийн талаарх мэдээллийг <http://www.iaf.nu>. цахим хуудаснаас авна уу.

**Нарийн бичгийн дарга нарын газар:**

ОУИФ-ын нарийн бичгийн дарга  
Утас: +1 613 454-8159  
И-мейл: [secretary@iaf.nu](mailto:secretary@iaf.nu)

**Further Information:**

For further Information on this document or other IAF documents, contact any member of IAF or the IAF Secretariat.

For contact details of members of IAF see the IAF website <http://www.iaf.nu>.

**Secretariat:**

IAF Corporate Secretary  
Telephone: +1 613 454-8159  
Email: [secretary@iaf.nu](mailto:secretary@iaf.nu)